

БАТЛАВ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГА *Мөнх-Эрдэнэ* Д.МӨНХ-ЭРДЭНЭ

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ЗАРИМ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТЫН БАЙДАЛД ДОТООД ХЯНАЛТ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ**  
2023.09.18

**Нэг. Зорилго**

Байгаль орчны салбарын бодлогын зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөө, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, төлөвлөлт, албан хаагчийн зохион байгуулсан үйл ажиллагаа, төлөвлөлт, тайлангийн чанарт дотоод хяналт хийх, зөвлөн туслах, илэрсэн зөрчлийг арилгахад чиглэнэ.

**Хоёр. Үндэслэл, хамрах хүрээ**

Эрх зүйн үндэслэл:

- Төрийн албаны хууль
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль
- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”

Дотоод хяналтын хамрах хүрээ: Дараах салбарын үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

- Аялал жуулчлалын салбарын хууль тогтоомж, бодлогын бичиг баримт, аялал жуулчлалыг хөгжүүлэх 2023 оны арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд дотоод хяналт хийх
- Байгаль орчны үнэлгээ, усны салбарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, тайлагналтад дотоод хяналт хийх

Хамрагдах албан хаагч:

- Аялал жуулчлал, тусгай хамгаалалттай газар нутаг, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
- Байгаль орчны үнэлгээ, усны асуудал хариуцсан мэргэжилтэн

**Гурав. Дотоод хяналт шалгалтын хугацаа**

Хяналт, шалгалтыг 2023 оны 9 сарын 18-23-ны өдрүүдэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Гандулам хийж гүйцэтгэнэ

**Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ**

1. Хяналт шалгалтыг албан хаагчийн цаасан болон цахим баримтад тулгуурлан гүйцэтгэнэ.
2. Хяналтын явц, үр дүнг нотлох баримт, фото зургаар баталгаажуулна.
3. Хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах, зөвлөгөө, зөвлөмж өгөх, хугацаатай үүрэг даалгавар өгөх
4. Дотоод хяналт шалгалтын дүн, танилцуулгыг газрын даргад танилцуулж, мэдээллийг цахим хуудаст байршуулах

**Тав. Дотоод хяналт, шалгалтын үр дүнг тайлагнах**

Дотоод хяналт хийсэн тухай үнэлгээ, дүгнэлт, тайланг даргад 2023 оны 9 сарын 25-нд танилцуулна.

Дотоод хяналт, шалгалтын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавина.

Удирдамж боловсруулсан:

Ахлах мэргэжилтэн

 Б.Гандулам